



**АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар A/100

Улаанбаатар хот

「Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ」  
худалдан авах төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.4, 3.13.2 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хангамжийн хэлтсийн дарга (Г.Эрдэнэбилэг), Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор (Б.Бямбасүрэн) -д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БАЯНМӨНХ



Амгалан дулааны станц ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 10 ны өдрийн  
№100 дугаар тушаалын хавсралт

### "АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨХК-ИЙН 2022 ОНЫ БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Эх үүсвэр: Өөрийн хөрөнгөөр									
Д/д	№	Тендер шалгаруулалтын код	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл	Батлагдсан төсөвт өртөг /мян.төг/	Тухайн онд санхүүжих дүн /мян.төг/	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам	Тендер зарлах огноо	Тайлбар
<b>ХАРЬЦУУЛАЛТЫН АРГА</b>									
1	1		Туузан дамжлагын тууз	Бараа	44,000.0	44,000.0	ХА	2022.06.24	
2	2		Уутат шүүлтүүрийн уут	Бараа	37,000.0	37,000.0	ХА	2022.06.23	
<b>Дүн</b>					<b>81,000.0</b>	<b>81,000.0</b>			
<b>ШУУД ХУДАЛДАН АВАЛТ</b>									
3	1		Халуун агаар үлээгч тень	Бараа	6,000	6,000.0	ШХА	2022.06.22	
4	2		Автомашин сэлбэг материал	Бараа	15,400	15,400.0	ШХА	2022.06.23	
5	3		Хийн компрессор /тусгай зориулалтын авто машины/	Бараа	9,500	9,500.0	ШХА	2022.06.24	
6	4		10кВ Утаа сорогч №3 цахилгаан хөдөлгүүрийн 1 болон 2 дугаар холхивч	Бараа	19,342	19,342.0	ШХА	2022.06.27	

7	5		Техникийн ус хангамжийн 2-р шугамыг засварлах	Ажил	19,000	19,000.0	ШХА	2022.06.27	
8	6		Галын хотол болон циклоны температурын датчик	Бараа	12,584.0	12,584.0	ШХА	2022.06.28	
9	7		Хими ус бэлтгэлийн удирдлагын системийн дижитал оролтын модуль	Бараа	8,900.0	8,900.0	ШХА	2022.06.29	
10	8		Үндсэн барилгаас захиргааны байр руу татах шилэн кабель	Бараа	4,161.0	4,161.0	ШХА	2022.06.30	
<b>Дүн</b>					<b>94,887.0</b>	<b>94,887.0</b>			
<b>ГЭРЭЭ ШУУД БАЙГУУЛАХ</b>									
11	1		Зуух №2-н их засварт шаардлагатай ган хоолой (60x5мм)	Бараа	42,595	42,595.0	ГШБ	2022.06.24	
12	2		Зуух №3-н их засварт шаардлагатай ган хоолой (60x5мм)	Бараа	40,161	40,161.0	ГШБ	2022.06.24	
<b>Дүн</b>					<b>82,756.0</b>	<b>82,756.0</b>			
<b>Нийт дүн</b>					<b>258,643.0</b>	<b>258,643.0</b>			





АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИГ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭС

2022 оны 06 дугаар сарын 09

Дугаар 41

Улаанбаатар хот

"Амгалан дулааны станц" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны .....дугаар сарын .....-ны өдрийн хурлын тэмдэглэл:

**...ХЭЛЭЛЭСЭН нь:** Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хангамжийн хэлтсийн дарга Г.Эрдэнэбилэг танилцуулав.

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Компанийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлттэй танилцаж хавсралтад тусгагдсан нийт 12 нэр төрлийн 258,643,002 төгрөгийн төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэн дэмжив.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Компанийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу батлагдсан төсөвт өртөгт багтаан зохион байгуулж, тайлагнахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгов гэжээ.

ДАРГА

Д.ДАВААСҮРЭН